**ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Хөвсгөл аймгийн Галт сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ХӨА-2025/076/НА-СТА-ТШ3**

Цахим хуудас: www.audit.mn

Мөрөн сум

2025 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг:tegshdelgerb@audit.gov.mn
Аудитор: Г.Ичинхорлоо
Утас:88688168 Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn
Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа
Утас:99389208 Цахим хаяг: b_myadagmaaa@yahoo.com
Аудитор Ц.Мөнхтуяа
Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 1/177

танай ________ -ны № ________ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ГАЛТ СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Ц.ХАЛТАР ТАНАА

**Хараат бус аудиторын дүгнэлт**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Галт сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Галт сумын эрүүл мэндийн төв нь 2024 онд Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,432,046.7 мянган төгрөгийн санхүүжилтийг авахаас 1,344,465.2 мянган төгрөгийг санхүүжилтийг авч 87,581.5 мянган төгрөгийн авлагатай гарсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нийт 10,497.5 мянган төгрөгийн 10 алдаа, зөрчил илэрснээс, 1 албан шаардлага, 6 зөвлөмж өгч, 3 алдааг залруулсан.

**Бусад асуудлын хэсэг**

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Галт сумын эрүүл мэндийн төвтэй байгуулсан анхан шатны тусламж үйлчилгээг худалдан авах 2024 оны гэрээний биелэлтийг 90.9 хувьтай дүгнэсэн байна.

6(...)21068

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **119,954,291.67** | **183,601,244.21** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 4,186,466.18 | 9,654,603.68 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 4,186,466.18 | 9,654,603.68 |
| **3121** | **Төгрөг** | 4,186,466.18 | 9,654,603.68 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 4,186,466.18 | 9,654,603.68 |
| **33** | **АВЛАГА** | 26,022,864.00 | 87,731,548.15 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 25,872,864.00 | 87,581,548.15 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 150,000.00 | 150,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 89,744,961.49 | 86,215,092.38 |
| **351** | **Түүхий эд материал** | 29,789,719.64 | 21,834,730.03 |
| 35130 | Эм боох материал | 29,789,719.64 | 21,834,730.03 |
| **354** | **Хангамжийн материал** | 59,955,241.85 | 64,380,362.35 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,112,900.00 | 1,307,400.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 43,016,497.61 | 49,552,835.61 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 3,511,900.00 | 1,417,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 2,045,728.00 | 1,834,910.50 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 10,268,216.24 | 10,268,216.24 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,043,032,973.36** | **1,070,346,283.87** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,043,032,973.36 | 1,070,346,283.87 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,021,430,973.36 | 1,048,744,283.87 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 988,629,914.43 | 988,629,914.43 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (120,626,479.23) | (147,066,274.05) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 67,196,100.00 | 92,196,100.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (31,339,695.50) | (38,566,430.17) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 154,064,409.72 | 227,703,195.12 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (46,579,204.65) | (80,199,222.76) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 28,609,712.00 | 28,884,712.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (18,907,568.64) | (23,098,473.08) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 808,382.20 | 808,382.20 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (466,396.97) | (589,419.82) |
| 39217 | Ном | 41,800.00 | 41,800.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 21,602,000.00 | 21,602,000.00 |
| 39301 | Програм хангамж | 550,000.00 | 550,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (550,000.00) | (550,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 21,602,000.00 | 21,602,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,162,987,265.03** | **1,253,947,528.08** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **6,302,700.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 6,302,700.00 |
| **413** | **Өглөг** | 00.00 | 6,302,700.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 00.00 | 5,600,700.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 00.00 | 702,000.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 00.00 | 702,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,162,987,265.03** | **1,247,644,828.08** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,162,987,265.03 | 1,247,644,828.08 |
| 511 | Засгийн газрын сан | 378,942,809.45 | 378,942,809.45 |
| 51101 | Өмч: - төрийн | 378,942,809.45 | 378,942,809.45 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 357,204,424.75 | 441,861,987.80 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 357,204,424.75 | 357,204,424.75 |

| | | | |
|---|---|---|---|
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 84,657,563.05 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 426,840,030.83 | 426,840,030.83 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,162,987,265.03** | **1,253,947,528.08** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,108,698,428.83** | **1,748,861,855.71** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **88,112,870.90** | **281,022,292.73** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 88,112,870.90 | 281,022,292.73 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 91,000.00 | 82,970,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 91,000.00 | 00.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 82,970,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 00.00 | 198,052,292.73 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,020,585,557.93** | **1,467,839,562.98** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 61,663,100.00 | 61,665,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 61,663,100.00 | 61,665,700.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 958,922,457.93 | 1,406,173,862.98 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 958,922,457.93 | 1,406,173,862.98 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,144,315,345.32** | **1,572,537,626.01** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,144,315,345.32** | **1,572,537,626.01** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,142,689,631.90 | 1,521,597,326.01 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 699,263,511.81 | 1,049,501,353.48 |
| 210101 | Үндсэн цалин | 437,740,571.85 | 613,204,144.98 |
| 210102 | Нэмэгдэл | 206,012,925.23 | 343,837,308.50 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 7,656,000.00 | 26,204,000.00 |
| 210104 | Урамшуулал | 47,854,014.73 | 66,255,900.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 88,289,771.91 | 130,739,115.85 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 60,283,411.27 | 88,330,202.41 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,097,796.90 | 10,495,178.91 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,585,429.36 | 6,088,528.39 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,390,380.32 | 5,142,779.03 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,932,754.06 | 20,682,427.11 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 54,205,886.58 | 56,324,400.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,666,344.58 | 4,923,324.87 |
| 210302 | Түлш, халаалт | 49,283,942.00 | 49,788,275.13 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,255,600.00 | 1,612,800.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 49,104,488.00 | 43,346,220.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,070,860.00 | 1,807,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 35,617,348.00 | 33,908,720.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,840,000.00 | 2,700,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,199,000.00 | 969,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,272,280.00 | 3,960,800.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 105,000.00 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 148,578,173.28 | 140,897,326.44 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 130,192,464.88 | 127,631,298.94 |
| 210502 | Хоол, хүнс | 18,385,708.40 | 13,266,027.50 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 9,874,500.00 | 6,666,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,874,500.00 | 6,666,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,826,000.00 | 1,563,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | 1,826,000.00 | 1,563,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,333,882.00 | 3,325,842.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,657,700.00 | 948,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,152,000.00 | 1,152,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 194,300.00 | 200,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 100,000.00 | 100,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 153,040.00 | 8,800.00 |
| 210807 | Газрын төлбөр | 76,842.00 | 76,842.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 00.00 | 839,700.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 88,213,418.32 | 89,233,168.24 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,786,000.00 | 9,299,360.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 79,427,418.32 | 79,933,808.24 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,625,713.42 | 50,940,300.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 250,000.00 | 50,940,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 50,940,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 250,000.00 | 00.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1,375,713.42 | 300.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,375,713.42 | 300.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(35,616,916.49)** | **176,324,229.70** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | 00.00 | 00.00 |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 91,666,666.65 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 00.00 | 91,666,666.65 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | (91,666,666.65) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(35,616,916.49)** | **84,657,563.05** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **994,803,691.93** | **1,489,100,878.83** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **90,998.00** | **82,970,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 90,998.00 | 82,970,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 90,998.00 | 82,970,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 90,998.00 | 00.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 82,970,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **994,712,693.93** | **1,406,130,878.83** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 61,663,100.00 | 61,665,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 61,663,100.00 | 61,665,700.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 933,049,593.93 | 1,344,465,178.83 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 933,049,593.93 | 1,344,465,178.83 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,023,489,721.72** | **1,449,932,741.33** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,023,489,721.72** | **1,449,932,741.33** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,021,864,008.30** | **1,398,992,441.33** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 700,310,583.72 | 1,049,465,465.48 |
| 210101 | Үндсэн цалин | 438,787,643.76 | 608,072,170.53 |
| 210102 | Нэмэгдэл | 206,012,925.23 | 362,407,526.95 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 7,656,000.00 | 23,489,270.00 |
| 210104 | Урамшуулал | 47,854,014.73 | 55,496,498.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 87,242,700.00 | 130,775,003.85 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 59,325,300.00 | 90,991,396.43 |

| | | | |
|---|---|---|---|
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,979,900.00 | 10,966,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,583,400.00 | 5,483,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,395,500.00 | 5,483,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,958,600.00 | 17,849,707.42 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 53,769,886.58 | 55,865,400.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,666,344.58 | 4,923,324.87 |
| 210302 | Түлш, халаалт | 48,847,942.00 | 49,329,275.13 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,255,600.00 | 1,612,800.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 43,681,330.00 | 41,721,820.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,897,800.00 | 2,001,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 31,313,050.00 | 32,272,820.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,700,000.00 | 2,700,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,199,000.00 | 969,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,571,480.00 | 3,777,800.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 98,306,466.00 | 97,524,650.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 86,806,426.00 | 84,469,440.00 |
| 210502 | Хоол, хүнс | 11,500,040.00 | 13,055,210.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 19,814,500.00 | 8,689,900.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 9,940,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,874,500.00 | 8,689,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,826,000.00 | 1,563,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,826,000.00 | 1,563,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,195,542.00 | 5,023,842.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,657,700.00 | 3,348,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,152,000.00 | 450,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 194,300.00 | 200,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 100,000.00 | 100,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 40,000.00 | 8,800.00 |
| 210807 | Газрын төлбөр | 76,842.00 | 76,842.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 974,700.00 | 839,700.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 12,717,000.00 | 8,363,360.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,717,000.00 | 8,363,360.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,625,713.42** | **50,940,300.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 250,000.00 | 50,940,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 50,940,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 250,000.00 | 00.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1,375,713.42 | 300.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,375,713.42 | 300.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **(28,686,029.79)** | **39,168,137.50** |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **00.00** | **00.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН** | **00.00** | **33,700,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **33,700,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | 33,700,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 33,700,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **00.00** | **-33,700,000.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (28,686,029.79) | 5,468,137.50 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 32,872,493.97 | 4,186,466.18 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 378,942,809.45 | 432,476,955.83 | (123,653,215.41) | 687,766,549.87 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 378,942,809.45 | 432,476,955.83 | (123,653,215.41) | 687,766,549.87 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 424,367,972.68 | 424,367,972.68 |
| 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 378,942,809.45 | 426,840,030.83 | 357,204,424.75 | 1,162,987,265.03 |
| 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 378,942,809.45 | 426,840,030.83 | 357,204,424.75 | 1,162,987,265.03 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 378,942,809.45 | 426,840,030.83 | 357,204,424.75 | 1,162,987,265.03 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 84,657,563.05 | 84,657,563.05 |
| 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 378,942,809.45 | 426,840,030.83 | 441,861,987.80 | 1,247,644,828.08 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
**Улсын төсвийн гүйцэтгэл:**

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | Зөрүү |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,507,330,200.00 | 1,421,967,041.33 | 94.34 | 85,363,158.67 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,507,330,200.00 | 1,421,967,041.33 | 94.34 | 85,363,158.67 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,427,330,200.00 | 1,371,027,041.33 | 96.06 | 56,303,158.67 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,096,688,600.00 | 1,049,465,465.48 | 95.69 | 47,223,134.52 |
| 210101 | Үндсэн цалин | 635,516,000.00 | 608,072,170.53 | 95.68 | 27,443,829.47 |
| 210102 | Нэмэгдэл | 391,966,200.00 | 362,407,526.95 | 92.46 | 29,558,673.05 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 19,220,000.00 | 23,489,270.00 | 122.21 | (4,269,270.00) |
| 210104 | Урамшуулал | 49,986,400.00 | 55,496,498.00 | 111.02 | (5,510,098.00) |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 137,086,200.00 | 130,775,003.85 | 95.40 | 6,311,196.15 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 93,218,600.00 | 90,991,396.43 | 97.61 | 2,227,203.57 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,966,900.00 | 10,966,900.00 | 100.00 | 0.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,483,500.00 | 5,483,500.00 | 100.00 | 0.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,483,500.00 | 5,483,500.00 | 100.00 | 0.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 21,933,700.00 | 17,849,707.42 | 81.38 | 4,083,992.58 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 42,056,300.00 | 41,721,820.00 | 99.20 | 334,480.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,150,300.00 | 2,001,700.00 | 48.23 | 2,148,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 30,092,500.00 | 32,272,820.00 | 107.25 | (2,180,320.00) |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,728,700.00 | 2,700,000.00 | 98.95 | 28,700.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,453,800.00 | 969,500.00 | 66.69 | 484,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,631,000.00 | 3,777,800.00 | 104.04 | (146,800.00) |
| **2105** | **Нормативт зардал** | 97,524,800.00 | 97,524,650.00 | 100.00 | 150.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 83,786,500.00 | 84,469,440.00 | 100.82 | (682,940.00) |
| 210502 | Хоол, хүнс | 13,738,300.00 | 13,055,210.00 | 95.03 | 683,090.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 34,930,000.00 | 32,889,900.00 | 94.16 | 2,040,100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 30,222,300.00 | 30,000,000.00 | 99.26 | 222,300.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 582,900.00 | 0.00 | 0.00 | 582,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,124,800.00 | 2,889,900.00 | 70.06 | 1,234,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,575,000.00 | 1,563,000.00 | 99.24 | 12,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,575,000.00 | 1,563,000.00 | 99.24 | 12,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,373,800.00 | 5,023,842.00 | 93.49 | 349,958.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,498,800.00 | 3,348,500.00 | 95.70 | 150,300.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 450,000.00 | 450,000.00 | 100.00 | 0.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 200,000.00 | 200,000.00 | 100.00 | 0.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 100,000.00 | 100,000.00 | 100.00 | 0.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 35,300.00 | 8,800.00 | 24.93 | 26,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 250,000.00 | 76,842.00 | 30.74 | 173,158.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 839,700.00 | 839,700.00 | 100.00 | 0.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 12,095,500.00 | 12,063,360.00 | 99.73 | 32,140.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,095,500.00 | 12,063,360.00 | 99.73 | 32,140.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 80,000,000.00 | 50,940,000.00 | 63.68 | 29,060,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 80,000,000.00 | 50,940,000.00 | 63.68 | 29,060,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 80,000,000.00 | 50,940,000.00 | 63.68 | 29,060,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,507,330,200.00 | 1,427,435,178.83 | 94.70 | 79,895,021.17 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,391,143,800.00 | 1,344,465,178.83 | 96.64 | 46,678,621.17 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 1,391,143,800.00 | 1,344,465,178.83 | 96.64 | 46,678,621.17 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 116,186,400.00 | 82,970,000.00 | 71.41 | 33,216,400.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 112,000,000.00 | 82,970,000.00 | 74.08 | 29,030,000.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 4,186,400.00 | 0.00 | 0.00 | 4,186,400.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 0.00 | 4,186,466.18 | | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 0.00 | 9,654,603.68 | | |

**Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | Зөрүү |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **61,665,700.00** | **61,665,400.00** | **100.00** | **300.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **61,665,700.00** | **61,665,400.00** | **100.00** | **300.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **61,665,700.00** | **61,665,400.00** | **100.00** | **300.00** |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 55,865,700.00 | 55,865,400.00 | 100.00 | 300.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,241,000.00 | 4,923,324.87 | 93.94 | 317,675.13 |
| 210302 | Түлш, халаалт | 49,011,600.00 | 49,329,275.13 | 100.65 | -317,675.13 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,613,100.00 | 1,612,800.00 | 99.98 | 300.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,800,000.00 | 5,800,000.00 | 100.00 | 0.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,800,000.00 | 5,800,000.00 | 100.00 | 0.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 61,665,700.00 | 61,665,400.00 | 100.00 | 300.00 |
| 32 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 61,665,700.00 | 61,665,400.00 | 100.00 | 300.00 |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 61,665,700.00 | 61,665,400.00 | 100.00 | 300.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 10,497.5 мянган төгрөгийн 10 алдаа, зөрчил илэрснээс, 1 албан шаардлага, 6 зөвлөмж өгч, 3 алдааг залруулсан.

### 3.1 Залруулсан алдаа

- Төсвийн жилд худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайланг гаргаж ирүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.3 заалтад заасан “тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл;” заалтыг хэрэгжүүлээгүй, “нийцсэн болон зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байсныг аудитын явцад нөхөж бэлтгэсэн.
- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн дүн Засгийн гзрын санхүүгийн удирдлага мэдээллийн системийн дүнгээс 813.5 мянган төгрөгөөр зөрүүтэй бэлтгэсэн нь  залруулж тааруулсан.
- Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал зөрчиж цалин, нийгмийн даатгалын шимтгэлийг бүлэг хооронд гүйлгэж хийсэн 4,084.0 мянган төгрөгийн гүйлгээг залруулсан.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 5,600.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 18,309.0 мянган төгрөгөөс 12,709.0 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 3.2 Албан шаардлага

Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор тогтоосон шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 20,000.0 мянган төгрөгөөс 38,056.2 мянган төгрөгөөр давсан дүнгээр худалдан авалт хийсэн, 22538.2 мянган төгрөгийн шатахууныг шууд худалдаж авсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 “Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно.” заалттай нийцэхгүй “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

*Илрүүлэлт:*

Тус эрүүл мэндийн төвийн мөрдөж байгаа Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь гүйцэтгэлийн санхүүжилтэд шилжсэнтэй холбоотой болон бусад шинээр гарсан дүрэм, журамтай нийцэхгүй болсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 ”Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн

бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.” заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан дүрэм, журамтай нийцүүлэн шинэчлэн боловсруулж, мөрдөх.

**2. Нягтлан бодох бүртгэлийн ажилтны урамшууллын талаар**

*Илрүүлэлт:*

Нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад урамшуулал олгохдоо холбогдох шалгуур үзүүлэлтүүдийг харгалзаж үзээгүй, зөвхөн 3өрчилгүй" санал дүгнэлт авсан гэсэн ганц шалгуураар 5,600.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23.2 заалт, Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалаар баталсан журмын 5.1 заалтад заасан шалгуур үзүүлэлт, Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4 заалтад заасан “Үр дүнгийн гэрээний биелэлт, хэрэгжилтийн явц байдалд үндэслэн...”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3-р хавсралт “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 1.2.1 заалтад “төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид;” мөнгөн урамшуулал олгохоор заасантай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад урамшуулал олгохдоо аудитын тайланд бичигдсэн болон бусад хяналтын байгууллагаас илрүүлсэн алдаа, зөрчил, өр, авлага, мэдээ, тайлангийн хугацаа, чанар зэрэг үзүүлэлтийг харгалзаж үзэх.

**3. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийн асуудал**

*Илрүүлэлт:*

2024 онд 1,422,878.8 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас нэхэмжилснээс 16,704.9 мянган төгрөг хасагдсан нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6 “эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх;”, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 05 дугаар тогтоолын 3.1 “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж,..” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны цахим системийн дотоод хяналтыг сайжруулж, хасагдалтын хэмжээг өмнөх оноос бууруулах.

**4. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал**

*Илрүүлэлт:*

Тайлант жилийн төсөвт орсон өөрчлөлтийг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил,

үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.", 48 дугаар зүйлийн 48.2.1 "Худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах;" Сангийн сайдын 2023 оны А/250 тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2.11 “Захиалагч цахим системд нийтэлсэн төлөвлөгөөг мөрдөж ажиллах ба энэ журмын 2.12-т заасан үндэслэлээр батлагдсан төлөвлөгөөнд орсон нэмэлт, өөрчлөлтийг холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын 10 өдөрт багтаан төлөвлөгөөнд өөрчлөлтийг тусган, батална. Хэрэв холбогдох дээд шатны байгууллага байгаа бол төлөвлөгөөний өөрчлөлтийг түүгээр батлуулахаар цахим системээр илгээж, өөрчлөлтийг баталгаажуулна.” гэж заасантай нийцэхгүй “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Тайлант оны төсөвт батлагдсан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг төлөвлөх, өөрчлөлт орсон тухай бүрд нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусган батлуулах.

**5. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

*Илрүүлэлт:*

Тус эрүүл мэндийн төв Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 32, зарлагын 13 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 8 шийдвэр, байгууллагын батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжид нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Шилэн дансны хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

**6. Ахмадын сангийн талаар**

*Илрүүлэлт:*

Галт сумын эрүүл мэндийн төв нь ахмадын сан байгуулаагүй байгаа нь Ахмадын настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 “Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах…” гэж заасантай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Ахмадын санг байгууллагын төсөвт тусгаж батлуулах, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан журмыг мөрдөж ажиллах

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл** /мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Төсвийн гүйцэтгэлийн тайланд худалдан авах ажиллагааны тайланг хавсаргаагүй. | 1 | - | 1 | - | | | 1 | - | | |
| Төсвийн эдийн засгийн ангилал зөрүүлж гүйлгээ хийсэн. | 1 | 4,084.0 | | | 1 | 4,084.0 | 1 | 4,084.0 | | |
| Төсвийн гүйцэтгэлийн тайланг зөрүүтэй дүнгээр бэлтгэсэн. | 1 | 813.5 | | | 1 | 813.5 | 1 | 813.5 | | |
| Дүн | **3** | **4,897.5** | **1** | **-** | **2** | **4,897.5** | **2** | **4,897.5** | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан дүрэм, журамд нийцүүлэн шинэчлээгүй. | 1 | - | | | | | 1 | - |
| Бүртгэлийн ажилтнуудад урамшуулал олгохдоо холбогдох шалгуур үзүүлэлтүүдийг харгалзаж үзээгүй, зөвхөн “Зөрчилгүй" санал дүгнэлт авсан гэж урамшуулсан байна. | 1 | 5,600. | | | | | 1 | 5,600.0 |
| **Дүн** | **2** | **5,600.** | | | | | **2** | **5,600.0** |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны цахим хуудсанд холбогдох мэдээллүүдийг хугацаа хоцроож мэдээлсэн. | 1 | - | | | | | 1 | - |
| Бараа материалын шууд худалдан авалтын дүн нь шууд худалдан авах төсөвт өртгийн дээд хязгаараас давсан. | **1** | **-** | | | **1** | **-** | | |
| Тайлант жилийн төсөвт орсон өөрчлөлтийг тусгаж худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулаагүй. | **1** | **-** | | | | | 1 | - |
| Эмнэлгийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийг цахим системд бүрэн, үнэн зөв оруулаагүйгээс нэхэмжилсэн санхүүжилтийг бүрэн авч чадаагүй. | **1** | **-** | | | | | 1 | - |
| Ахмадын санг байгууллагын төсөвт тусгаж, батлуулаагүй | **1** | **-** | | | | | 1 | - |
| Дүн | **5** | **-** | | | **1** | **-** | **4** | - |

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |

| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| | **НИЙТ** | 1 | 1 | | | 1 | | | |

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр — № б1/А22 70469/ ХӨА-2025/076/НА-СТБ-ХИЗ — Мөрөн сум

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Галт сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны эмийн шууд худалдан авалтын дүн нь "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор тогтоосон шууд худалдан авч болох барааны төсөвт өртгийн дээд хязгаараас 38,056,230 (Гучин найман сая тавин зургаан мянга хоёр зуун гуч) төгрөгөөр хэтэрсэн, 22,538,230 (Хорин хоёр сая таван зуун гучин найман мянга хоёр зуун гуч) төгрөгийн шатахууныг шууд худалдаж авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно." заалттай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.9-т "*Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол*" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа Засгийн газраас тогтоосон шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг баримтлан ажиллаж, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор гаргаж, төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд оруулж, баталгаажуулах;
2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Галт сумын Эрүүл мэндийн төвийн дарга Ц.Халтар, нягтлан бодогч Д.Дэлгэрмаа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: А.ЭРДЭНЭБААТАР

АУДИТОР Г.ИЧИНХОРЛОО

6724020473